

Organizers



MINISTRY OF INDUSTRY AND
MINERAL RESOURCES



MINERAL RESOURCES AND
PETROLEUM AUTHORITY



MONGOLIAN NATIONAL
MINING ASSOCIATION

MONGOLIAN MININGWEEK | MINEPRO | 2025

EXPO | CONVENTION

ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОГЧДОД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ

4th annual

INTERNATIONAL
MINING EXHIBITION
AND CONVENTION



11,12,13
September



Taij Khaikhan, Nalaikh District,
Ulaanbaatar, Mongolia



Visit now
www.miningweek.mn
www.minepro.mn

АГУУЛГА

Ерөнхий танилцуулга	3
Үзэсгэлэнгийн өмнөх бэлтгэл	5
Үзэсгэлэнгийн үеийн дүрэм, журам	6
Павильоны мэдээлэл	8
Гадна талбайн бэлтгэл ба хүнд техник ашиглах	10
Гадна талбай дахь аюулгүй ажиллагаа	12
Эрүүл мэнд, аюулгүй байдлын зөвлөмж	13
Үзэсгэлэнгийн дараах (буулгах) заавар	15

Зохион байгуулагчтай холбоо барих

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Скай Плаза Бизнес Центр, 2-р байр.

Утас:

Үндсэн зохион байгуулагч:	+976 72106690	+976 88106381
	+976 72504103	+976 88889878

Талбайн зохион байгуулагч: +976 94209333

Цахилгаанчин: +976 99095509

Ерөнхий танилцуулга


“MiningWeek & MinePro 2025” нь уул уурхайн салбарын ирээдүйн чиг хандлага, ашигт малтмалын зах зээлийн эрэлт хэрэгцээг хэлэлцэх зорилготой олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалт юм. Энэхүү арга хэмжээнд уул уурхайн худалдан авагчид, ханган нийлүүлэгчид, салбарын мэргэжилтнүүд оролцож, хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулна.

Үзэсгэлэн 2024 оны 9 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Тайж хайрханы бэлд зохион байгуулагдана.

Энэхүү удирдамж нь үзэсгэлэнд оролцогч байгууллагуудад зориулагдсан ба үзэсгэлэнгийн өмнө, үеэр болон дараа өөрсдийн дотор павильон (бүүт) болон гадна талбай дахь байршуулалтаа хэрхэн, хэзээ, ямар дүрэм журмын дагуу барьж байгуулах талаарх дэлгэрэнгүй зааварчилгаа өгч байна. Бүх оролцогч талууд дараах заавар, дүрэм шаардлагуудыг мөрдөн ажиллаж, олон улсын стандартад нийцсэн байдлаар үзэсгэлэнд оролцоно уу.

Огноо: 2025 оны 09-р сарын 11-13

Байршил: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Тайж хайрханы бэл



— Засмал зам 37 km
— Шороон зам 4.7 km

Үзэсгэлэнгийн өмнөх бэлтгэл

1. Дотор талбайн павильон, бүтээн байгуулалт

Хугацаа: 2025 оны 9-р сарын 7–10

Үйл ажиллагаа: Павильон, павильон угсралт, засал чимэглэл.

Шаардлага:

- Зохион байгуулагчийн өгсөн зааварчилгаа, дүрмийг чанд мөрдөнө.
- Бүх ажлыг зөвшөөрсөн хугацаанд багтаан дуусгах шаардлагатай.

2. Сурталчилгааны материалын бэлтгэл

Хугацаа: Үзэсгэлэн эхлэхээс 24 цагийн өмнө

Бэлтгэх зүйлс:

- Танилцуулга брошюр, сурталчилгааны материал
- Баннер болон бусад хэрэгсэл

Шаардлага: Материалуудыг цаг хугацаанд нь лангуун дээр байршуулсан байх ёстой, ингэснээр үзэсгэлэн эхлэх үед зочдод саадгүй мэдээлэл түгээх боломжтой.

3. Гадна талбайн асар, тоног төхөөрөмж байршуулалт

Хугацаа: 2025 оны 9-р сарын 3–10

Үйл ажиллагаа:

- Асар, карказ угсралт
- Том оврын техник, тоног төхөөрөмжийн байршуулалт
- Материалын тээвэрлэлт, лангуу засалт

4. Цахилгаан хэрэглээний шаардлага

Эх үүсвэрийн байрлал: Гадна талбайд цахилгаан эх үүсвэр нь хамгийн ихдээ 50 м-ийн зайд байрлана.

Шаардлага:

- Оролцогчид өөрсдийн хэрэгцээнд тохирсон, 50 м хүртэл дамартай найдвартай утас авч ирэх.
- Утас нь зөвшөөрөгдсөн хүчин чадлыг даахуйц, аюулгүй байх ёстой.

Цахилгаан холболт:

- 2025 оны 9-р сарын 8–10 хооронд холбогдоно.
- Бүтээн байгуулалтаа бүрэн дуусгасан аж ахуйн нэгжүүдийг эхний ээлжинд холбоно.

Үзэсгэлэнгийн үеийн дүрэм, журам

Албан ёсны удирдамжтай танилцах

- Бүх оролцогч байгууллага үзэсгэлэнгийн дүрэм, удирдамжтай заавал танилцаж, мөрдөх үүрэгтэй.

Аюулгүй байдлын заавар

- Лангуу барих, тоног төхөөрөмж суурилуулах, засал хийх үед бүх аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөнө.
- Аюулгүй байдлыг хангах нь хүний эрүүл мэнд, эд хөрөнгийн хамгаалалттай шууд холбоотой.

Цагийн хуваарийг баримтлах

- Үзэсгэлэнгийн албан ёсны цагийн хуваарийг (нээлт, хаалт гэх мэт) дагаж мөрдөнө.
- Өөрийн хариуцсан талбайд байнга байж, үйл ажиллагаагаа хэвийн явуулна.

Хохирлын хариуцлага

- Лангуу болон талбайд гарсан эвдрэл, хохирол, алдагдалд зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.

Олны хөдөлгөөний зам чөлөөтэй байлгах

- Павильоны орц, гарц болон аваарын гарцыг хаах, саад учруулахыг хориглоно.
- Эдгээр замыг чөлөөтэй байлгах нь аюулгүй байдлын үндсэн нөхцөл.

Бусдын талбайд халдахгүй байх

- Өөрийн талбайн хэмжээг мөрдөж, бусдын лангуун дээр зөвшөөрөлгүй хүрэхгүй.
- Дуу чимээ, гэрэлтүүлэг, байрлалаа бусдад саад учруулахгүйгээр тохируулна.

Зохион байгуулагчаас гарах өөрчлөлт

- Болзошгүй нөхцөл байдлаас үүдэн павильон, талбайн байршил өөрчлөгдөх боломжтой.
- Үүсэх аливаа шууд бус хохиролд зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.

Ачаа зөөвөрлөлт

- Тусгай техник (өргөгч машин, сэрээт өргөгч гэх мэт) ашиглах бол урьдчилан зөвшөөрөл авч, зааварчилгаа авсны дараа ашиглана.
- Зөвшөөрөлгүйгээр хүнд машин механизм хөдөлгөхийг хориглоно.

Тамхины хэрэглээ

- Зөвхөн тамхины зориулалтын цэгүүдэд тамхи татна.
- Тамхины иш, хогийг зориулалтын саванд хийнэ.

Цэвэрлэгээ, хог хаягдал

- Лангуу болон ойр орчмын талбайг байнга цэвэр, эмх цэгцтэй байлгана.
- Хог хаягдлыг зөвхөн зориулалтын сав эсвэл заасан цэгт хаяна.

Бусдын эд хөрөнгийг хүндэтгэх

- Зохион байгуулагч болон бусдын тоног төхөөрөмж, эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэх, ашиглахыг хориглоно.
- Танхимын тохижилтыг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.

Тээврийн хэрэгслийн зогсоол

- Машиныг зөвхөн заасан тусгай зогсоолд байрлуулна.
- Ачаа буулгах үед зөвшөөрсөн бүсэд, товлосон цагт түр хугацаагаар байрлаж шуурхай гарна.

Дуу чимээний зохицуулалт

- Хөгжим, микрофон, өсгөгч ашиглахдаа дууны түвшин 70–80 дБ-аас хэтрэхгүй.
- Хурал, семинарын үеэр бусдад саад болохуйц дуу чимээ гаргахгүй.

Галын аюулгүй байдал

- Павильон бүрт гал унтраагуур байрлуулсан байх шаардлагатай.
- Цахилгааны ачааллыг хэтрүүлэхгүй, олон залгуур хэрэглэхдээ анхаарна.

Дүрэм зөрчигчдөд авах арга хэмжээ

- Хууль болон дүрмийг ноцтой зөрчсөн оролцогчдыг үзэсгэлэнгээс хасах, талбайг чөлөөлүүлэх эрхтэй.

Павильоны мэдээлэл


Павильоны хэмжээ ба төлөвлөлт

Стандарт хэмжээ: 3м x 3м (квадрат талбай), нийт өндөр 2.4м

Төлөвлөлт: Оролцогчид өөрийн тоноглол, өрөлт, үзүүлэнг энэ хэмжээний хүрээнд төлөвлөнө.

Павильоны дугаар ба нэрийн хаяг

- Зохион байгуулагч бүх павильонд дугаар болон байгууллагын нэрийн хаягийг байршуулна.
- Нэмэлт том хаяг хийх шаардлагагүй, өгөгдсөн загварыг ашиглана.



Стандарт павильоны иж бүрдэл

Багцад багтах зүйлс: 2 ширээ, 3 сандал, 2 гэрэл, шалны хивс, 220В цахилгааны нэг залгуур

Нэмэлт хэрэгцээ: Хэрэв тавилга, тоног төхөөрөмж нэмж хэрэглэх бол урьдчилан мэдэгдэж захиалах эсвэл өөрсдөө авчрах боломжтой.

Цахилгаан хангамж

Хүчдэл: 220В

Шаардлага: Өөрийн цахилгаан хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хүчдэлийн хэлбэлзэл, богино залгаанаас сэргийлэх, өндөр хүчин чадал шаардсан төхөөрөмж ашиглах бол зохион байгуулагчтай зөвшилцөх.

Засал чимэглэлийн өндөр ба бүтэц

Өндрийн хязгаар: Асрын захын хэсэг 4 метр, дунд хэсэг 5 метр
Барьж буй бүтээн байгуулалт, чимэглэлийн өндөр 4–5 метрээс хэтрэхгүй.

Дээвэр, шаланд бэхлэх хориотой үйлдлүүд

- Павильоны тааз, дээвэрт зүйл өлгөх хориотой.
- Шаланд өрөмдөж цоолох, бэхлэхийг хориглоно.
- Эвдрэл гаргавал нөхөн төлбөр хариуцна.
- Зохион байгуулагчаас зөвшөөрөгдсөн бэхлэх хэрэгсэл (соронзон наалт, хоёр талт скоч) авах боломжтой.

Нэмэлт тоноглол ба цахилгааны аюулгүй байдал

- Дэлгэц, өсгөгч, нэмэлт гэрэлтүүлэг зэрэг төхөөрөмжийг найдвартай бэхэлж, аюулгүй байдлыг хангана.
- Цахилгааны утсыг ил задгай тавихгүй, хэт ачаалал үүсгэхгүй.
- Автомат таслуур, тогтворжуулагч хэрэглэхийг зөвлөж байна.



Сандал

Height: 75 cm
Width: 50 cm
Length: 100 cm



Дугуй ширээ

Height: 75 cm
Width: 50 cm
Length: 100 cm




Дөрвөлжин ширээ

Height: 75 cm
Width: 60 cm

Гадна талбайн бэлтгэл ба хүнд техник ашиглах

Том оврын төхөөрөмжийн байршуулалт

- Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийг үзэсгэлэнгийн бэлтгэлийн хугацаанд (2025.9.3–9.10) талбайд авчирч, буулгаж, байрлуулна.
- Талбайд оруулахдаа зохион байгуулагчийн зааварчилгааг дагаж, хөдөлгөөний аюулгүй байдал, замын зохицуулалтыг чанд мөрдөнө.



Кран, өргөгч төхөөрөмж ашиглах

- Зөвхөн талбайн нөхцөлд тохирсон хүчин чадалтай краныг ашиглана.
- Аюулгүй ажиллагааны бүх дүрмийг мөрдөж, зөвхөн мэргэшсэн оператороор ажиллуулна.

Мэргэшсэн ажилтан ажиллуулах

- Өргөгч, татлага, дохиоллын ажлыг зөвхөн сургалт, дадлага хангагдсан оператор, туслах ажилтнууд хийнэ.
- Туршлагагүй ажилтнаар жолоодуулахыг хатуу хориглоно.

Өдөр тутмын өмнөх шалгалт

- Краны оператор бүр өдөр бүр ашиглахын өмнө тусгай шалгах хуудас ашиглан төхөөрөмжийн бүх аюулгүйн системийг шалгана.
- Механик гэмтэл илэрвэл ажиллагааг эхлүүлэхээс өмнө засварлаж шийдвэрлэнэ.

Ачаа өргөх замнал, саадыг төлөвлөх

- Өргөлтийн замыг урьдчилан төлөвлөж, бүх саад, тээглүүрийг арилгана.
- Цахилгааны шугам, багана зэрэг үл хөдлөх саадыг тойрон эсвэл зохих зайтайгаар ажиллана.

Ачааны жингийн хязгаар

- Краны даацын хүснэгтийг нарийвчлан судалж, зөвшөөрөгдсөн жингээс хэтрүүлэхгүй.
- Хэт ачаалал нь хамгийн том эрсдэл тул зөвшөөрөгдсөн жинг л өргөнө.

Харилцаа холбоо ба дохиоллын систем

- Кран ажиллаж байх үед оператор болон дохиочин нар тодорхой, зөв дохио болон холбоогоор харилцана.
- Дохиочин нь өргөлтийн явцад операторыг чиглүүлж, орчны өөрчлөлтийг тухай бүр мэдээлнэ.
- Нарийн төвөгтэй өргөлт хийх төлөвлөгөө
- Краны даацын 80% (эсвэл хөвөгч суурин дээр 50%)-иас дээш жинтэй ачааг өргөх нь “нарийн төвөгтэй өргөлт” гэж тооцогдоно.
- Энэ тохиолдолд тусгай төлөвлөгөө боловсруулж, мэргэшсэн оператор, хүчирхэг кран ашиглана.

Гадна талбайн асар, байгууламж

- Асар майхан, түр байгууламжийг найдвартай бэхэлж, салхи, цаг агаарын нөхцөлд тэсвэртэй байлгах шаардлагатай.
- Газардуулга, бэхэлгээг сайтар хийж, галын аюулгүй байдлын үндсэн шаардлагыг хангана.
- Асар хоорондын зай, гарц гаргалгаа зэргийг зохих хэмжээнд баримтална.

Гадна талбайд ажиллах ба аюулгүй ажиллагаа

Хамгаалалтын хувцас, хэрэгсэл (PPE)

- Гадна талбай нь ил задгай орчин тул цаг агаар, орчны онцлогт тохируулан хамгаалах хувцас хэрэглэнэ.
- Хүнд техниктэй харьцахдаа ган ултай гутал, хамгаалалтын малгай, шаардлагатай бол бээлий, нүдний шил, чихэвч, амны хаалт зэргийг заавал өмсөнө.
- Том оврын техник ажиллуулах, зөөх үед орчны хүмүүсийг аюулгүй зайд байлгаж, хөдөлгөөний хяналтыг тусгай хүн хариуцна.

Цахилгаан болон шатахууны хэрэглээ

- Гадна талбайд байрлах техник, төхөөрөмж цахилгаан болон шатахуун ашиглах бол аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээг авна.
- Генератор, түлш хадгалах савыг зориулалтын дагуу байрлуулж, ил гал, оч үүсэхээс сэргийлнэ.
- Кабель, утсыг ус, чийгнээс хамгаалж, бүдэргээ үүсгэхгүй байдлаар байрлуулна.

Хяналт, харуул хамгаалалт

- Том оврын тоног төхөөрөмжийг үзэсгэлэнгийн бус цагт харуул хамгаалалт хянах ч, оролцогч өөрийн эд хөрөнгийн хамгаалалтад нэмэлт анхаарал тавина.
- Боломжтой бол камер, дохиолол, хүн хүч ашиглах; үүсэх аливаа хохирлыг оролцогч өөрөө хариуцна.

Эрүүл мэнд, аюулгүй байдлын зөвлөмж

Хамгаалалтын хувцас ба хэрэгсэл

- Бэлтгэл болон буулгалтын үед бүх оролцогчид каск, хамгаалалтын шил, бээлий, шаардлагатай бол амны хаалт, өндөрт ажиллах бүс, гагнуурын баг гэх мэт хэрэгслүүдийг хэрэглэнэ.
- Гадаа талбайд ажиллах бол ган ултай хамгаалалтын гутал, каск өмсөхийг зөвлөж байна.

Ажлын багаж, тоног төхөөрөмж ашиглалт

- Цахилгаан хөрөө, дрилл, зүсэгч зэрэг багаж хэрэгсэл ашиглахдаа хамгаалалтын шил, бээлий, чихэвч заавал өмсөнө.
- Ашиглахаас өмнө төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгана; гэмтэлтэй, засвар хийгдээгүй төхөөрөмж ашиглахыг хориглоно.

Хүнд механизм, өргөгч төхөөрөмжийн орчин

- Сэрээт өргөгч, кран зэрэг техник ажиллаж байх үед орчны хөдөлгөөнд анхааралтай байж, шаардлагагүй үед ойртохгүй.
- Өөрийн төхөөрөмж байрлуулах үед мэргэшсэн ажилтнуудад ажлыг даатгаж, бусдыг аюулгүй зайд байрлуулна.

Бэхэлгээ, суурилуулалт

- Лангуун доторх самбар, дэлгэц, тавиур зэрэг эд зүйлийг найдвартай, бат бөх бэхэлнэ.
- Эд ангиуд сулрах, унах эрсдэлээс сэргийлэхийн тулд угсралтыг туршлагатай хүмүүсээр хийлгэж, өдөр тутам шалгана.

Осол, аюул мэдээлэх

- Химийн бодис асгарах, сэжигтэй нөхцөл илрэх зэрэгт даруй зохион байгуулагчид мэдэгдэнэ.
- Зохион байгуулагч шуурхай арга хэмжээ авах тул цаг алдалгүй мэдээлэл өгөхийг хэвшил болгоно.

Гулгалт, бүдэрч унахаас сэргийлэх

- Танхимд кабель, босго, шингэн асгарсан хэсэг зэрэг бүдэрч, хальтирч болзошгүй саадыг арилгах.
- Лангуун ойролцоох шалыг тогтмол цэвэр, саадгүй байлгах.

18-аас доош насныхныг хориглох

- Бэлтгэл, буулгалтын үед үзэсгэлэнгийн талбай нь барилгын бүстэй адил аюултай тул 18 нас хүрээгүй хүүхэд, өсвөр насныхныг талбайд байлгахыг хориглоно.

Хувийн эрсдэлийн хариуцлага

- Бүх оролцогч өөрийн болон байгууллагын эд хөрөнгө, ажилтнуудын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн эрсдэлийг бүрэн хариуцна.
- Зохион байгуулагч нийтлэг орчны аюулгүй байдлыг ханган ажиллах ч, өндөр хүчдэлтэй төхөөрөмж, галын аюултай ажилбар, үнэт эд зүйлсийн хамгаалалт зэрэг тусгай эрсдэлийг оролцогч өөрөө хариуцна.

Галын хор байрлуулах

- Түрээсэлсэн талбайд заавал зөөврийн гал унтраагуур байрлуулсан байх шаардлагатай.
- Галын хорны ажиллагааг тогтмол шалгаж, хөрш оролцогчидтойгоо байршлыг харилцан мэдэж авна.

Аваарийн гарц, анхны тусламж

- Аваарийн гарц, гамшгийн үеийн цугларах цэгийг төлөвлөлтийн зураг дээрээс урьдчилан танилцана.
- Анхны тусламжийн цэгийн байршлыг мэдэж, осол, өвчлөлийн үед шуурхай тусламж дуудах, анхны тусламж үзүүлэхэд бэлэн байна.

Хараа хяналтгүй эд зүйлс үлдээхгүй байх

- Цүнх, хайрцаг, тоног төхөөрөмж зэрэг эд зүйлсийг хараа хяналтгүй орхихыг хориглоно.
- Хараа хяналтгүй орхисон эд зүйл нь хулгайд өртөхөөс гадна аюулгүй байдлын эрсдэл үүсгэж болзошгүй тул хамгаалалтын алба шалгалт хийх боломжтой.

Эд хөрөнгийн хамгаалалт, хариуцлага

- Үзэсгэлэнгийн талбай (дотор болон гадна) дахь эд зүйлс, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжид учирсан аливаа хохирлыг зохион байгуулагч тал хариуцахгүй.
- Оролцогч өөрийн хөрөнгийг хамгаалах үүрэгтэй. Үнэт тоног төхөөрөмж, экспонатыг шөнөд нь цоожлох, аюулгүй газар хадгалах эсвэл хамгаалалтын хүн томилохыг зөвлөж байна.

Үзэсгэлэнгийн дараах (буулгах) заавар

1. Лангуу, байгууламж буулгах журам

- Үзэсгэлэн дууссаны дараа оролцогч бүр өөрийн лангууны засал чимэглэл, тоног төхөөрөмж, бүтээн байгуулалтыг зохион байгуулагчийн тавьсан шаардлага, дүрэм журам, аюулгүй ажиллагааны зөвлөмжийн дагуу буулгаж хураана.
- Павильон доторх нэмэлт байгууламж, самбар, гэрэлтүүлгийг анхны суурилуулалтын зааврын дагуу буулгаж, орчныг гэмтээлгүй анхааралтай ажиллана.

2. Гаргах хугацаа, хуваарь

- Үзэсгэлэнгийн талбайгаас бараа, тоног төхөөрөмж, материалыг гаргах албан ёсны хугацаа: 2025 оны 9-р сарын 14 – 9-р сарын 21.
- Энэ хугацаанд лангууны бүх зүйлсийг ачиж, зөөвөрлөх боломжтой.
- Зохион байгуулагч талаас урьдчилан мэдэгдсэн нарийвчилсан хуваарийг (жишээ нь, бүсчилсэн байдлаар, цагийн хуваарийн дагуу) мөрдөнө.

2025 ОНЫ 9-Р САРЫН 13-НД БУУЛГАЛТ ХИЙХИЙГ ХАТУУ ХОРИГЛОНО.

3. Санал хүсэлт өгөх

- Үзэсгэлэн өндөрлөсний дараа өөрийн сэтгэгдэл, санал хүсэлтээ зохион байгуулагчид илгээнэ үү.
- Холбогдох сувгууд:
- Утас: 976-72504103
- И-мэйл: partnership@minepro.mn
- Таны санал дараагийн арга хэмжээг сайжруулахад үнэтэй хувь нэмэр болно.

4. Холбоо барих мэдээлэл

- Хэрэв нэмэлт асуулт, тусламж хэрэгцээ гарвал зохион байгуулагчтай холбогдоно уу.
- Зохион байгуулагч: Манай байгууллага уг үзэсгэлэнгийн зохион байгуулагчаар ажиллаж байна.
- Харилцах хүн: _____